



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

АГУУЛГА

НЭГ. ХҮНИЙ НӨӨЦ

ХОЁР. ШИНЭЭР САНААЧИЛСАН БҮТЭЭЛЧ АЖИЛ

ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА, СУРГАЛТ

ДӨРӨВ. ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

ТАВ. БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

- Иргэний улсын бүртгэл
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
- Хуулийн этгээдийн улсын бүртгэл
- Архивын чиглэлээр хийсэн ажил

ЗУРГАА. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР

ДОЛОО. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТ

НАЙМ. БУСАД

НЭГ. ХҮНИЙ НӨӨЦ



- Магистр-5
- Бакалавр-24
- Бүрэн дунд -1

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахаар Сити Их сургуулийн эрхзүйн бакалаврын эчнээ ангид 5 албан хаагч, Глобал Удирдагч Их сургуульд эрхзүйн бакалаврын эчнээ ангид 3 албан хаагч, Орхон Их сургуулийн эрх зүйн эчнээ ангиад 2 нийт 10 албан хаагч суралцаж байна.

- 2022 онд 4 албан хаагч шинээр томилогдож, тэтгэвэрт 1 албан хаагч гарсан байна.
- Төрийн албан хаагчийн дэлгэрэнгүй, Төрийн албанд ажилласан жилийн, зэрэг дэвийн, нас, хүйс, боловсрол, мэргэжил гэх мэт суурь 3 судалгааг шинэчлэн гаргаж УБЕГ-т хүргүүлсэн.
- Төрийн захиргааны 4, төрийн үйлчилгээний 2 сул орон тооны мэдээллийг байгууллагын www.dornod.burtgel.gov.mn цахим хаягт байршуулж мэдээлж ажиллав.
- УБЕГ-ын Тэргүүний ажилтан цол тэмдгээр 5 албан хаагч, ХЗДХЯ-ны "Хүндэт жуух бичиг"-ээр 3 албан хаагч, УБЕГ-ын "Хүндэт жуух бичиг"-ээр 4 албан хаагч тус тус шагнагдсан.



Д/д	Тушаал, шийдвэр	Төрөл	Албан хаагчдын тоо
1.	УБЕГ-ын даргын 2022 оны Б/189	Гэрээт албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоох тухай	2
2.	Хэлтсийн даргын 2022 оны А/01	ТАХ-ын албан тушаалын цалингийн шатлал ахиулах	16
3.	Хэлтсийн даргын 2022 оны А/04	Тусламж олгох	1
4.	Хэлтсийн даргын 2022 оны А/06	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл шинэчлэн тогтоосон	3
5.	Хэлтсийн даргын 2022 оны А/07	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэн урамшуулал олгосон	16
6.	Хэлтсийн даргын 2022 оны Б/10	Төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалингийн шатлал шинэчлэн тогтоох тухай	4
7.	Хэлтсийн даргын 2022 оны Б/12	Урамшуулал олгох тухай	17
8.	Хэлтсийн даргын 2022 оны Б/342	Цалин шинэчлэн тогтоох тухай	1

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 10.2-т заасны дагуу албан хаагчдын цаг ашиглалтыг хянах зорилгоор зөвшөөрөл авсны үндсэн дээр нүүр таних программ ашиглаж байна.



ХОЁР. ШИНЭЭР САНААЧИЛСАН БҮТЭЭЛЧ АЖИЛ

Тус хэлтэс нь 2022 оныг “БҮРТГЭЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ЖИЛ” болгон зарлаж, зорилтот жилийн хүрээнд мэдээллийн байнгын найдвартай шуурхай үйлчилгээг хангаж, бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээллийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг бүрдүүлэн “МЕССЕНЖЕР - ЧАТ БОТ” автомат хариулагч, “QR - ЦАХИМ ХӨТӨЧ”-ийг тус тус шинээр санаачлан хэрэгжүүлсэн. Иргэд гар утасны камераараа QR кодыг уншуулан бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээллийг бүрэн авах боломжтой.



”ЦАХИМ БУЛАН”-гаа шинэчилэн иргэд цахим үйлчилгээний нэгдсэн систем E-mongolia ашиглан улсын бүртгэлийн 22 төрлийн лавлагаа, 54 төрлийн үйлчилгээг авах таатай нөхцлийг бүрдүүлсэн.



Улсын бүртгэлийн ажилтны баярын өдрийг угтан 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр ”ЦАХИМ ӨДӨРЛӨГ” зохион байгуулав. Өдөрлөгийн хүрээнд гадаад паспорт дахин захиалах, иргэний цахим үнэмлэх дахин захиалах, лавлагаа, эд хөрөнгөтэй эсэх лавлагаа, эд хөрөнгийн түүхчилсэн лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ, хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалт, цахим гэрчилгээ олголт, emongolia-үйлчилгээг сурталчлах, тоон гарын үсгийг олгох үйлчилгээг цахимаар үзүүлж нийт 76 иргэнд үйлчилсэн.



Улсын бүртгэлийн байгууллагын хууль тогтоомж болон бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор Монгол Улсын Их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургуулийн ахлах ангийн 88 сурагчдын дунд бүртгэлийн тухай хуулийн асуултууд орсон ТАНИН МЭДЭХҮЙН “АХА” тэмцээнийг зохион байгуулж, бэлэг дурсгалын зүйлээр урамшууллаа.



Иргэний улсын бүртгэлийн 1412 хайрцган хадгаламжийн сангийн хаягжилтыг “**ХОС БИЧВЭР**”-ээр шинэчилж, дугаарлалт хийж 100 хувь дуусгалаа.



ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА, СУРГАЛТ

2022 онд хийж хэрэгжүүлэх ажил, үүрэгтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай 5 зорилтын хүрээнд 37 арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргатай 6 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, биелэлтийг ханган ажиллалаа.



Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор жил бүр зохион байгуулдаг “Монгол Улсын иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагааг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран “АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ”-ыг зохион байгуулж, 16 нас хүрч иргэний үнэмлэхээ авч буй өсвөр үеийн төлөөлөл залуус Монгол Улсын иргэний андгайгаа өргүүллээ.





Аймгийн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг Төрийн албаны ерөнхий шалгалтад орж байгаа иргэдийн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу хурууны хээний бүртгэлийг хийж хамтран ажилласан.



Аймгийн Иргэдийн Төлөөгчдийн Хурлын 2021 оны 7/09 дүгээр тогтоолоор батлагдсан сумдын хүн амд үйлчлэх “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ” төсөл арга хэмжээний хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчид бүртгэлийн үйлчилгээг 13 сумын иргэдэд үзүүлж ажиллалаа.

Сумдад ажиллахдаа Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, бусад хууль дүрэм журмын хүрээнд газар болон үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээний талаарх мэдээлэл, зөвлөгөөг 524 иргэнд үзүүлж, газар болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 192 гэрчилгээг гаргаж, олгож ажиллалаа. Үүнд:

1. Төрөөс хувьчилсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх- 4
2. Төрөөс хувьчилсан газар өмчлөх эрхийг анх удаа бүртгэх- 145
3. Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх- 6
4. Худалдах худалдан авах гэрээ – 16
5. Өмчлөгч өөрт ногдох хэсгээ худалдах гэрээ -5
6. Өмчлөгч өөрт ногдох хэсгээ бэлэглэх гэрээ -6
7. Өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх -1
8. Лавлагаа – 9
9. Бэлэглэлийн гэрээ - 9
10. Иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн, 16, 25, 45, насны хугацаа хэтрэлтэй 9 иргэнийг /160.000 төгрөг/

11. Төрсний гэрчилгээ үрэгдүүлсэн иргэний өргөдөл 1 авч торгуулиас чөлөөлж ажиллав.



Төрийн аудитын газартай хамтран 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Тусгаар тогтнолын талбай болон Найрамдал парк дээр Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, 91 иргэнд тоон гарын үсэг олгож, зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллалаа.





Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд энэ оны 09 дүгээр сарын 15-29-ний өдрүүдэд Цагдаагийн газартай хамтран Дорнод аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага / хүнсний дэлгүүр, түц, зочид буудал, бар, караоке/ иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэх, гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг хууль бусаар барьцаалсан үйлдэл байгаа эсэхийг шалгаж, зөрчилтэй 4 баримт бичгийг хураан авч ажилласан.



Сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллаж, Баяндун сум 3,850,000 төгрөгний, Цагаан-Овоо сумын 4 235 000 төгрөгний үнэтэй дижитал киоск машиныг тус тус шийдвэрлүүлсэн.



Аймгийн МСҮТөвтэй хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд тус сургалт үйлдвэрлэлийн төвөөс зохион байгуулсан “Мэргэжил бүхэн сайхан” мэргэжил сурталчилах сарын аяны “Шилдэг түншлэгч” байгууллагаар шалгарлаа.



Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газартай хамтран Дашбалбар суманд Нээлттэй өдөрлөг зохион байгуулж, 80 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 33 иргэний газар болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг олгож ажиллалаа.



Иргэд, олон нийтэд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, бүртгэлийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор аймаг, суманд зохион байгуулсан 8 удаагийн Нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож, 380 иргэн, 26 хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.





Аймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн албан хаагчдын дунд санаачлан зохион байгуулсан “Түнх харваа-Монгол бичиг”-ийн тэмцээнд багаараа амжилттай оролцож, 31 байгууллагаас 9 дүгээр байр эзэлсэн.



СУРГАЛТ:

Сургалтын ажлын хэсэг нь 2022 онд 17 нэр төрлийн сургалт зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгаснаас тайлант онд нийт 161 сургалт /бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 26 сургалт, албан хаагчдын хандлага, хариуцлага, ёс зүйн чиглэлээр 9, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан болон хамтарсан сургалт 129, сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр 2/-ыг тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор 1050 албан хаагч хамрагдаж, төрийн байгууллагын 9200 гаруй албан хаагчийг хамруулж ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан 39 удаагийн онлайн сургалтад /бүртгэлийн чиглэлээр-21, хяналт, шалгалтын чиглэлээр-4, сонгууль-2, бусад -12, давхардсан тоогоор нийт 975 албан хаагч, танхимын 2 удаагийн сургалтад 2 албан хаагч бүрэн хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.

Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх “Тоон гарын үсгийн талаарх” сургалтыг 93 байгууллагын 9200 гаруй албан хаагчдад хүргэж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. Нийт 11929 иргэнд тоон гарын үсэг олгосон нь 16 ба түүнээс дээш насны иргэдийн 22 хувийг эзэлж байна.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



ДӨРӨВ. ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Улсын бүртгэлийн ерөнхий газар болон хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг цаг тухай бүрт нь www.dornod.burtgel.gov.mn, www.facebook.com/Ubh.dornod цахим хуудаснаа нийтлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд цаг үе, үйл явдалтай холбоотойгоор 173, иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулах чиглэлээр цахим хуудсаар хууль сурталчлах 203 баннер, зурагт мэдээлэл байршуулж, цахим хуудасны сэтгэгдэл, захиагаар хандсан 105 иргэнд зохих мэдээлэл, зөвлөгөөг хүргэж ажилласан. www.facebook.com/Ubh.dornod фэйсбүүк хуудас нь 7530 дэмжигчидтэй байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс УБЕГ-ын www.burtgel.gov.mn, аймгийн Засаг даргын Тамгын газрын www.dornod.gov.mn хуудсанд тавигдсан мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд хуваалцаж, иргэдийг мэдээ мэдээллээр тогтмол ханган ажиллалаа.




Бүртгэлийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах зорилгоор цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдөр “Иргэний үнэмлэх анх удаа авах”, 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр “Иргэний үнэмлэхийн 25, 45 насны сунгалт хийхэд анхаарах асуудал”, 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр “Өмчлөгч өөрт ногдох хэсгээ бусдад худалдах, бэлэглэх гэрээг хэрхэн бүртгүүлэх”, 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчөөр хэрхэн бүртгүүлэх”, “Хоршооны шинэчилсэн бүртгэлийг эрчимжүүлэх талаар” зэрэг сэдвээр тус тус мэдээлэл бэлтгэн байгууллагын цахим хуудас www.dornod.burtgel.gov.mn сайт болон Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк хуудас, орон нутгийн телевизээр дамжуулан иргэдэд хүргэн ажилласан.





Мөн орон нутгийн Japan.mn сайт, ТВ6, Дорнод ТВ, Шинэ суваг телевизүүдэд “E-mongolia үйлчилгээ”, “Цахим тоон гарын үсэг”, “Үндэсний гадаад паспорт”-ийн талаар тус тус мэдээлэл өгч ажилласан.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг төрийн үйлчилгээний цахим систем ө Mongolia системийг ашиглан



Аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудыг зөвлөгөө, мэдээ, мэдээллээр хангаж өгөх зорилгоор **“ДОРНОД АЙМГИЙН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА”** цахим хуудсыг тогтмол ажиллуулан хэвшээд байна.



Улсын бүртгэлийн үйлчилгээг Burtgel.mn болон E-Mongolia-с цахимаар авах боломжтойг иргэдэд сурталчлан ажиллалаа.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС




Байгууллагын “**НЭЭЛТТЭЙ УТАС 98-970-970**” дугаараас иргэд бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн мэдээллийг авах боломж бөгөөд тайлант хугацаанд 701 иргэнд үйлчлүүлсэн.




Улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, түргэн шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлээр үйлчилгээний төлбөр, хураамжийг боловсронгуй болгох, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх зорилгоор **ГЭРЭГЭ КИОСК** байршуулсан бөгөөд тайлант хугацаанд 19845 иргэнд үйлчилж ажилласан.

Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдээс тогтмол санал, хүсэлтийг хүлээн авч, тухай бүр зөвлөгөө өгч ажилласан.





Улсын бүртгэлийн үйлчилгээний гарын авлагыг шинэчлэн гаргаж байгууллагын www.dornod.burtgel.gov.mn цахим сайт болон Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк хуудсаар дамжуулан тогтмол сурталчлан ажиллалаа.



QR - ЦАХИМ ХӨТӨЧ –ийг үйлчилгээний байгууллага болон банк санхүүгийн байгууллага, хот хоорондын автобус, байгууллагын самбар, хаалга гэх мэт иргэдэд аль болох хүртээмжтэй газарт наан байршуулсан бөгөөд иргэд уг QR кодыг гар утсаараа уншуулан улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээллийг цаг алдалгүй авах боломжоор ханган ажилласан.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Байгууллагын ил тод нээлттэй байдлыг ханган ажиллах үүднээс байгууллагын ухаалаг самбарт мэдээллийг тогтмол болон байнга шинэчлэн байршуулан ажиллав.



ТАВ. БҮРТГЭЛ, ХЯНАЛТ


Хэлтсийн даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу 2022 онд хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн зөрчил илрүүлэн арилгах, зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоох, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бүртгэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилтыг тавьж ажиллалаа. Үүнд:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/289 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын дагуу 20 удаагийн хяналт шалгалтыг хийж, 1177 бүртгэлд хяналт тавьж ажилласан.

Иргэний улсын бүртгэлийн 686 буюу 58,2%, эх нотлох, баримтыг шалгахад 10 зөрчил илэрч, улсын бүртгэгчээр зөрчлийг арилгуулан ажилласан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 250 буюу 21,2%, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 136 буюу 11,6%, архивын 105 буюу 9% хувийн хэргийг татаж шалгахад тус тус зөрчил илрээгүй.

Мөн хэлтсийн даргын хяналт шалгалт хийх батлагдсан төлөвлөгөөний Баян-Уул, Булган, Сэргэлэн, Халхгол, Цагаан-Овоо, Матад, Хэрлэн сумдын 2457 бүртгэлийн бүрдүүлбэр эх нотлох баримтад түүвэрчилсэн шалгалтыг хийхэд зөрчил илрээгүй.

2021-2022 оны хяналт шалгалт хийсэн харьцуулсан үзүүлэлт:



Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 223 иргэн, хуулийн этгээдээс өргөдөл гомдлыг хүлээн авч тухайн шатанд шийдвэрлэн иргэдэд утсаар мэдэгдэж, хариу өгч ажилласан. Үүнээс: Иргэний бүртгэлтэй холбоотой 141, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 81, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой 1 дүгнэлтийг нотлох баримтанд үндэслэн зөрчлийг арилгаж, тухай бүр мэдээллийн санд засвар өөрчлөлтийг тусгуулан иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авч ажилласан.

Тайлант хугацаанд 55 иргэний үндэсний энгийн гадаад паспортыг мэдээллийн санд хүчингүй болгосон байна.

Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 626 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, зөрчил шалган шийдвэрлэсэн хэрэг материалыг хуульд заасан хугацаанд холбогдох прокурорт хянуулан зөрчлийн хэргийн бүртгэл хөтөлж, тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Улсын бүртгэгч нарт бүртгэлийн үйлчилгээний талаар 2 удаагийн заавар, зөвлөмж чиглэл хүргүүлэн ажилласан.

УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хүртэлхи хугацаанд хийсэн ИУБ-ийн 724 бүртгэлийн эх нотлох баримт бичиг улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд бүртгэгдсэн эсэхийг цахим хэлбэрээр шалгахад ямар нэгэн зөрчил илрээгүй, ЭХЭУБ-ийн 526 бүртгэлийг шалгахад 16 зөрчил илэрч, бүртгэлийн үйлчилгээний зөрчлийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч тус бүрээр нь нэн даруй арилгуулав.

Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар, өөрчлөлт оруулах хяналтын улсын байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн №1500 дүгнэлтийг үндэслэн EPRS системд засвар өөрчлөлт оруулах бүртгэлийн жагсаалтыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчид хүргүүлж засварлуулж ажиллав.

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Иргэний улсын бүртгэлийн тасаг нь 2022 оны 01 дүгээр сарын 05-ны тасгийн хурал хийсэн бөгөөд уг хурлаар тасгийн улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нарын ажил үүргийн хуваарийг шинэчилж ажилласан.

УБЕГ-ын Тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 3/127 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, ИУБГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/134 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, ИУБГ-аас 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 4/522 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, УБНА-ын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10/797 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, УБНА-ын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10/1536 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, ИУБГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 4/3001 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, ИУБГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 4/4386, ИУБГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний 4/4585 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, ИУБГ-аас 2022 оны 06 дугаар 21-ний өдрийн 4/5460 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, УБЕГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 3-1/7979 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, УБЕГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 1/8275 оот албан бичгээр ирүүлсэн “Гадаад паспорт хөтлөх тухай” чиглэл, УБЕГ-ын УБНА-ын даргын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 10/8406 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, ИУБГ-аас 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр цахимаар ирүүлсэн Гадаад паспорт хөтлөхөд анхаарах асуудал, УБЕГ-ын даргын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/1301 тоот тушаал, ИУБГ-ын даргын 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 4/9443 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, ИУБГ-ын даргын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 4/9698 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг хяналтандаа авч, хэрэгжилтийг тус тус ханган ажилласан.

Иргэний улсын бүртгэлийн газраас өгсөн үүрэг, даалгаврын дагуу “Цахимжуулалт хийж байгаа эсэх талаарх” илтгэх хуудсыг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

Иргэний улсын бүртгэлийн газраас өгсөн үүрэг, даалгаврын дагуу тус аймгийн харъяат 100 ба түүнээс дээш настай иргэний судалгааг нягтлан шалгаж, илтгэх хуудсыг 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

Иргэний улсын бүртгэлийн газраас өгсөн үүрэг, даалгаврын дагуу 2021.07.01-2021.12.31-ний өдрийн хооронд тус аймагт олгогдсон лавлагааны тоон мэдээг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр ИУБГазар цахимаар хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газраас 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10/797 тоот албан бичгээр ирүүлсэн тус аймагт хамаарах 103 иргэний ИУБ маягтыг / ИУБ /ХААТР/ 11–102, ИУБ /ХААТР/ 12-16, ИУБ /ХААТР/ 13-5, ИУБ /ХААТР/ 14–1/ цахим мэдээллийн санд бүртгэж, цахимжуулж илтгэх хуудсыг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр УБНА-т цахимаар хүргүүлсэн.

ИУБГ-т 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хүчингүй болгох 112 хаягийн судалгааг хүргүүлсэн.

Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 4/2584 тоот албан бичгээр ирүүлсэн “Иргэний үнэмлэхийн бүртгэл шалгах тухай” үүрэг

даалгаврын хүрээнд 2020, 2021, 2022 оны 03 сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд бүртгэсэн нийт 6753 иргэний үнэмлэхийн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нягтлан шалгаж, илтгэх хуудсыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.

ИУБГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу 2021 оны 01 дүгээр сарын 02-ноос 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл олгогдсон 856 үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн е дугаарыг мэдээллийн санд нягтлан шалгаж, шалгалтын явцад е дугаар тавигдаагүй 45 иргэний гадаад паспортын дугаарыг мэдээллийн санд нөхөн оруулж зөрчлийг арилган, илтгэх хуудсыг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.

ИУБГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр үндэсний энгийн гадаад паспорт-22, иргэний цахим үнэмлэхний 391 бүртгэлийг хүчингүй болгож, илтгэх хуудсыг ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.

ИУБГ-аас 2022 оны 06 дугаар 21-ний өдрийн 4/5460 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу иргэний улсын бүртгэгч нарт гадаад паспортын зураг авах болон гадаад паспортын материал хүлээн авахад анхаарах асуудал сэдвээр сургалт зохион байгуулж, илтгэх хуудсыг 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдөр ИУБГ-т хүргүүлсэн.

2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг ашигладаг 22 албан хаагчдын судалгааг ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.

УБЕГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 1/7421, 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 1/7706 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлүүд, ажлын хэсгийн 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ИУБГ-ын даргын 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 4/9443 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 14 сумын улсын бүртгэгчид гэрлэсний, гэрлэлт дуусгавар болсны, иргэний үнэмлэхний, нас барсны бүртгэлийн эрхийг нээлгэж, 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн баталгаажуулалт хийж, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд баталгаажуулсан бүртгэлийг нягтлан шалгахад гарсан зөрчил байхгүй болно.

ИУБН-ын даргын 2022 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 4/9698 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу тайлант хугацаанд ХУБ-ийн 2021 оны 6839 дугаар дүгнэлтээр - 9, ХУБ-ийн 2022 оны 1543 дугаар дүгнэлтээр - 3, хэлтсийн ХУБ-ийн дүгнэлтээр - 3 иргэний зөрчлийг тус тус арилган ажилаласан.

Хяналтын улсын байцаагчийн 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 6256 дугаар дүгнэлтийг хяналтандаа авч ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд гадаад паспортын дугаар мэдээллийн сан дахь дугаартай зөрүүтэй тохиолдол гараагүй.

2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу шалгалтад оролцогч 115 иргэний бүртгэлийг хурууны хээгээр бүртгэж оруулсан.

Тайлант хугацаанд иргэдэд тоон гарын үсэг олгох талаар төлөвлөгөөг тухай бүрт нь гарган ажиллаж, албан хаагчдыг хуваарилан төрийн болон төрийн бус 93 байгууллагатай хамтран ажиллаж 11929 иргэнд тоон гарын үсгийг олгож ажиллалаа. Тоон гарын үсэг олгох хуваарь, тайлан мэдээг холбогдох газарт тухай бүрт нь хүргүүлэн ажилласан.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 18384 бүртгэл бүртгэгдсэн.

Үүнийг ангилвал:



Мэдээллийн сангийн зөрчил арилгах болон мэдээллийн санд тусгуулахаар ИУБГ болон МТГ-т албан бичгээр хүргүүлсэн мэдээлэл:

Д/д	Төрөл	Тоо
1.	Дахин, нөхөн үсгийн алдаатай	526
2.	Нэрийн санд хаяггүй иргэдийн хаягжуулсан	70
3.	Гэрлэлтийн төлөв засах	615
4.	Мэдээллийн санд шинээр хаяг тусгуулах	110
5.	БОЭТ-өөс регистрийн дугаар буруу олгосон	25
6.	ХУБ-ийн дүгнэлтээр регистрийн дугаар олгосон	6
7.	Цахимжуулсан хувийн хэргийн тоо	518
НИЙТ		1870

УБЕГ-ын Тамгын газраас 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 3/7450 тоот албан бичгээр ирүүлсэн хуулийн төсөлд саналыг 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр цахимаар хүргүүлсэн.

Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд саналыг 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.

“Улсын бүртгэлийн байгууллагаас энгийн гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтын бүртгэл хөтлөх журам”-д тусгах саналыг 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.

2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл хөтлөх саналыг УБЕГ-ын Тамгын газарт цахимаар хүргүүлсэн.

АНСДИТХ-ийн нөхөн сонгуулийн хүрээнд:

Баянтүмэн, Сэргэлэн, Хөлөнбуйр суманд орон нутгийн нөхөн сонгууль болохтой холбогдуулан дээрх сумдын сонгуулийн тов, нутаг дэвсгэрийг зарласан ИТХТ-ыг мэдээллийн санд 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр скайнардан, шивж оруулсан.

ИУБГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолд заасан сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн сонгуулийн эрх бүхий иргэнийг СНЖ-д бүрэн бүртгэсэн эсэхийг нягтлан шалгаж, илтгэх хуудсыг ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.

УБЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/284 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, илтгэх хуудсыг ИУБГ-т 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны нөхөн сонгуулийн СНЖ-д бүртгэлтэй эсэхээ шалгах <http://www.election.burtgel.gov.mn> холбоосыг тогтмол сурталчилан ажиллаж байна.

Аймаг, нийслэл сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны нөхөн болон дахин сонгуульд ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудын судалгааг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.

Аймаг, нийслэл сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны нөхөн болон дахин сонгуульд ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудад нууцтай харьцан ажиллах зөвшөөрлийг хэлтсийн 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 285 тоот албан бичгээр тагнуулын байгууллагад хүргүүлсэн. Тагнуулын байгууллагаас 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 35/91 тоот албан бичгээр нууцтай харьцан ажиллахыг зөвшөөрсөн зөвшөөрлийг үндэслэн итгэмжлэгдсэн ажилтнуудыг тушаалаар томилж, гэрээ байгуулан ажиллаж байна.

2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр ИУБГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу УДШ, ШШГЕГ, ХХЕГ, БХЯ, ЦЕГ, ГИХГ-аас сонгуулийн ерөнхий хороогоор дамжуулан ирүүлсэн иргэдийн мэдээллийг үндэслэн сонгогчийн нэрийн жагсаалтад төлөв оноосон мэдээллийг нягтлан шалгаж, илтгэх хуудсыг 2022 оны 05 дугаар 03-ны өдөр ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.

2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр АНСДИТХ-ын нөхөн сонгуулийн СНЖ-ыг хэвлэж, 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарыг байлцуулан сонгогчдын нэрийн жагсаалтыг хуулийн хугацаанд нь хүлээлгэн өгч, илтгэх хуудсыг 2022 оны 05 дугаар 25-ны өдөр ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.





ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийт бүртгэсэн **8653** бүртгэлийн **10.9%** хувийг газар өмчлөх болон газар эзэмших эрхийн бүртгэл, **6.1%** хувийг газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл, **44.5%** хувийг барьцааны гэрээ, **24.1%** хувийг өмчлөх эрх шилжих гэрээ, **10%** хувийг хувийн хэрэг хаах, лавлагаа хуулбар, **4.3%** хувийг гэрээ хэлцлээс бусад эрхийн улсын бүртгэл эзэлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн эрх түдгэлзүүлсэн тухай 26 албан бичгээр 34 үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлж, эрх сэргээх тухай 15 албан бичгээр ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн 23 үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг сэргээн ажиллав.

“Монголын ипотекийн корпораци”-ийн 2022 оны 22/15, 22/25, 22/17, 22/20, “Үнэт цаас санхүүжилтийн корпораци”-ийн 124/22, 544/22, 635/22 тоот албан бичгүүдээр “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багц”-ыг тусгай тэмдэглэл хийж бүртгүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч худалдах, худалдан авах гэрээнд /ипотекийн зээл/ тусгагдсан 5 банкны 323 ширхэг эд хөрөнгөнд тусгай тэмдэглэл хийж, мэдээллийн санд бүртгэж хариуг хүргүүлж ажиллав.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хууль хяналтын байгууллагад 90 албан бичгээр 160 иргэн, хуулийн этгээдийн лавлагаа хуулбарыг олгож ажилласан.


Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаалаар 48 газар, 14 үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг хаах бүртгэлийг мэдээллийн санд бүртгэж ажилласан. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн 8/7219 чиглэлийн дагуу хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр үрэгдүүлсэн 53 газар, 18 үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцож шинээр гэрчилгээг бичиж олгосон.

УБЕГазрын ХШГазрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн №1500 дүгнэлтийг үндэслэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 13200 хувийн хэргийн цахим мэдээллийн санг архивын хувийн хэргийн цаасан нотлох баримттай тулган шалгаж 235 хувийн хэрэгт, УБЕГазрын ЭХЭУБГазрын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 6/9582 дугаартай хугацаатай үүрэг даалгаврын дагуу 1318 хувийн хэргийн мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулж, мэдээллийн санд баяжилт хийж ажиллав.


Аймгийн Иргэдийн Төлөөгчдийн Хурлын 2021 оны 7/09 дүгээр тогтоолоор батлагдсан сумдын хүн амд үйлчлэх “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ” төсөл арга хэмжээний хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчид бүртгэлийн үйлчилгээг 13 сумын иргэдэд үзүүлж ажилласан.

Сумдад ажиллахдаа Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, бусад хууль дүрэм журмын хүрээнд газар болон үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээний талаарх мэдээлэл, зөвлөгөөг 524 иргэнд үзүүлж, 192 гэрчилгээг гаргаж, өмчлөгчид хүлээлгэн өгч ажиллалаа.


Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл




Газар өмчлөх эрхийн улсын бүртгэл




Гэрээний эрхийн бүртгэлийн тоо




Барьцааны гэрээ, барьцааны эрх дуусгавар болгох бүртгэл



Бусад бүртгэл



Лавлагаа, хуулбар өгөх



Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар Сэргэлэн, Цагаан-Овоо, Баяндун сумдын улын бүртгэгч эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгосон.

Эрх олгогдсон улсын бүртгэгч нарыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр сургалтад хамруулж, ажлын байранд 7-14 хоног дадлагажуулж бүртгэл хөтлөх бэлэн байдлыг хангаж, тамга тэмдэг, үнэт цаасыг хүлээлгэн өгч ажиллав. Сэргэлэн, Цагаан-Овоо, Баяндун сумын 156 иргэнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэв.



ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Тайлант хугацаанд 1747 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зөвлөгөө өгч, мэдээ мэдээллээр ханган Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн бөгөөд “Монгол улсын тэмдэгтийн хураамжийн хууль”-ийн дагуу 22.549.0 мян.төгрөгийн хураамжийг улсын болон орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлэв.

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, эрх зүйн актын хүрээнд дараах ажил үүргийг гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Засгийн газрын 237 дугаар тогтоолын 6.1 дүгээр зүйлийн дагуу 209 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын оноосон нэрийг баталгаажуулж 2.090.0 мян.төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлэв.
- 197 аж ахуйн нэгж, байгууллага шинээр үүсгэн байгуулагдан үйл ажиллагаа эрхлэн явуулах зөвшөөрөл авч, хуульд заасан хугацаанд холбогдох баримт бичгийг бүрдүүлсэн тул улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгов.
- 640 нэр төрлийн нэмэлт өөрчлөлтийг цахим мэдээллийн санд оруулж, шинэчилсэн болон үрэгдүүлсэн, гэмтээсэн /шилжиж ирсэн/ шалтгаанаар 57 аж ахуйн нэгж, байгууллагад дахин гэрчилгээг тус тус олгосон. Үүний дотор хувийн 2 аж ахуйн нэгж, байгууллага хэлбэрээ өөрчилж бүртгүүлэв.
- Хуулийн этгээдийн салбар 13 салбарын шинээр бүртгэсэн. Дорнод аймагт бүртгэлтэй 19 салбарт нэмэлт өөрчлөлт оруулсан.
- Аймгийн татварын хэлтсийн татварын байцаагч болон хяналт шалгалтын тасгийн байцаагч нараар шалгагдаж өр төлбөрөө бүрэн барагдуулан холбогдох баримт материалаа бүрдүүлж татан буугдахаар хүсэлт гаргасан 6 аж ахуйн нэгж, байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасч татан буулган, хувийн хэргийг архивлан хэлтсийн архивт шилжүүлсэн. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хэлбэр регистр, оноосон нэр өөрчилсөн, татан буугдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын 59 тамгыг хураан авсан.
- Тайлант хугацаанд Төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн 63 албан бичгийг хүлээн авч 39 албан бичигт хариу хүргүүлэн ажиллалаа. Хууль хяналтын байгууллагаа ирүүлсэн хүсэлтийн дагуу 11 лавлагаа гарган хүргүүлж ажилласан.
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын цахим мэдээллийн сангаас 17 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн этгээдэд лавлагаа /тодорхойлолт/ олгож ажилласан.
- Мөн иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх, гэмтээсэн, оноосон нэр, хэлбэр өөрчилсөн үрэгдүүлсэн гэх мэт үндэслэлээр 277 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тамганы хяналтын дугаар олгох үйлчилгээ үзүүлсэн.

- Сумдын улсын бүртгэгч нарт тухай бүр арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр “Хуулийн этгээдийн бүртгэл” нэртэй “www.facebook.com” цахим хуудас ажиллуулж хэвшсэн бөгөөд сумдын улсын бүртгэгч нарт 20 удаа хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар утсаар болон биечлэн зөвлөгөө өгч ажилласан.

АРХИВ:

2022 онд архивт хийж гүйцэтгэх 3 бүлэг 14 заалт бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулан, хэлтсийн даргаар батлуулан ажилласан.

Иргэний улсын бүртгэлийн тасгийн архив

Иргэний улсын бүртгэлийн архивт 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 177699 хувийн хэрэг, ИУБ, ХААТР маягтууд хадгалагдаж байна.

Хяналтын улсын байцаагч болон улсын бүртгэгч нарт 415 ширхэг хувийн хэрэг татан өгч, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 670 иргэний хувийн хэрэг ХААТР маягтуудыг хувийн хэргийн хадгаламжийн санд байршуулан ажиллаж байна. Мөн аймаг сумдаас бүр мөсөн шилжин явсан 601 иргэний ИУБ маягт хувийн хэргийг холбогдох орон нутагт нь хүргүүлсэн. Иргэний улсын бүртгэгч нараас 6109ш ИУБ маягтуудыг хүлээн авч байршуулсан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 43796 хувийн хэрэг хадгалагдаж байна. Эд хөрөнгийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны явцад бий болсон нэмэлт өөрчлөлтийн 7183 нотлох баримт, шинээр үүсгэсэн газар өмчлөх эрхийн анхны бүртгэл 944, газар эзэмших, ашиглах 1230, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэл 526 хувийн хэрэг архивт хүлээн авч байршуулсан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цаасан хувийн хэргийг цахим мэдээллийн сантай тулган шалгахтай холбогдуудан 12000 ширхэг хувийн хэрэг, мөн бүртгэлийн үйл явцад шалгах шаардлагатай 195 ширхэг хувийн хэргийг улсын ахлах бүртгэгч болон улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгсөн. Архивын мэдээ тайланг тухай бүрт ньгарган холбогдох газарт цахимаар хүргүүлэн ажилласан

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 6/3763 тоот албан бичгээр чиглэлийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын хувийн хэрэг, нотлох баримтуудыг нягтлан шалгаж, 59778 тусгаарласан хуудсыг жагсаалт үйлдэн хувийн хэргээс ангилан авч, устгалд оруулах жагсаалт үйлдэн УБНА-т хүргүүлсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт **2752** аж ахуйн, нэгж байгууллагын хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнийг хэлбэр тус бүрээр нь харуулвал. Үүнд:

1. Хувьцаат компани	9
2. Хязгаарлагдмал хариуцлагатай компани	1961
3. Төрийн бус байгууллага	311
4. Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	1
5. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	17
6. Төрийн байгууллага, албан газар,	

улсын төсөвт үйлдвэрийн газар	162
7. Нөхөрлөл	91
8. Хоршоо	85
7. Хадгаламж зээлийн хоршоо	9
8. Сан	27
9. Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	72
10. Шашины байгууллага	8
11. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	1
12. Боловсрол сургалтын байгууллага	5
13. Эрдэм шинжилгээний байгууллага	0

Мөн үүнээс гадна шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 113 төрийн бус байгууллагын хувийн хэрэг баримт материалууд архивт байршиж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цаасан хувийн хэргийг цахим мэдээллийн сантай тулган шалгахтай холбогдуулан 1170 хувийн хэрэгт тооллого хийж, улсын бүртгэгчид хүлээлгэн өгсөн. Тайлант хугацаанд шинээр үүссэн аж ахуй нэгжийн 199, нэмэлт өөрчлөлтийн 640 нотлох баримтыг хүлээн авч, холбогдох журмын дагуу байршуулсан.

Архивын мэдээ тайланг тухай бүрт нь гарган холбогдох газарт цахимаар хүргүүлэн ажилласан.

Бусад ажил:

УБНА-аас 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр ирүүлсэн чиглэлийн дагуу 2021 онд хадгалах хугацаа нь дууссан архивын санд хадгалагдаж байгаа иргэний гэр бүлийн байдлын хадгаламжийн нэгж, иргэний улсын бүртгэлийн 27210 хуудас баримт бичиг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт хураагдсан тамга тэмдэг, 2021 оны 08 дугаар сард иргэний улсын бүртгэлийн газрын мэдээллийн сан шинэчлэгдсэнтэй холбогдуулан гарсан үнэт цаас, иргэний үнэмлэхний зураг засварлах сумын улсын бүртгэгч нараас ирүүлсэн 2018 оноос хойш хуримтлагдсан CD-нүүдийг /ББНШК-ын гишүүн/ Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б.Болор-Эрдэнэ, архивч С.Батчимэг /ББНШК-ын гишүүн/, Бичиг хэргийн ажилтан Т.Сэржмаа, архивын гэрээт ажилтан Э.Цолмончимэг нар 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14.30 цагаас 16.20 цаг хүртэл Дорнод аймгийн “Нисэх онгоцны буудал”-ын уурын зууханд устгаж дууссан.



ЗУРГАА. САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тус хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын газарт хүргүүлэн санхүүгийн аудит хийлгэж, Төрийн аудитын газраас “ЗӨРЧИЛГҮЙ” дүгнэлттэй үнэлэгдсэн.

Тайланг хугацаанд 412.857.100 төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаа явуулж 399.190.282,15 төгрөгийн буюу 97% төсвийн гүйцэтгэлтэй, 13,666,817.85 төгрөгийн буюу 3%-ийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй ажилласан.

Улсын төсөвт 173.236.102,55 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Батлагдсан төсвийн хүрээнд мөнгөн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулах, төсвийн зардлыг бууруулах ажлын хүрээнд орон нутгийн аж ахуй нэгжүүдээс үнийн судалгаа явуулж, бичгийн цаас нэг бүрийг 3911 төгрөгөөр хямд худалдан авч 215,100 төгрөгөөр, аймгийн Тагнуулын байгууллагатай хамтран ажиллан албан бичиг илгээлтийн зардлыг 575,000 төгрөгөөр, нийт 780.100 төгрөгийн бодит хэмнэлттэй ажиллав.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг, үнэт цаас зарцуулалтын тайланг хуулийн хугацаанд УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст хүргүүлсэн.

Бараа материал худалдан авах зорилгоор 13 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан, худалдан авалтад 12.077.904,40 төгрөгийг зарцуулсан.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж www.shilendans.gov.mn, байгууллагын www.ubh.dd.gov.mn сайтад 133 мэдээлэл байршуулахаас 132 мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв байршуулан 99.2% хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

ДОЛОО. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан 36 санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч тухай бүрт нь шийдвэрлэж хариу өгч ажилласан. Үүнийг ангилвал:

Хэлбэр	Тоо
Гомдол	8
Хүсэлт	0
Өргөдөл	28
Талархал	0
Нийт	36

Тус хэлтэст гаргасан 8 гомдлын 4 нь нэг иргэнээс нэг асуудал /өргөдлөөр -1, 7058-2233 буюу ЗДТГ-ын нээлттэй утсанд -2, байгууллагын нээлттэй утас 98-970-970 дугаарт-1/-аар бүртгэл хүчингүй болгуулахаар гомдол гаргасан бөгөөд уг бүртгэл нь хуулийн хүрээнд үнэн зөв бүртгэгдсэн бүртгэл байсан. Тухай бүрт нь хяналтын газраас зөвлөгөө авч хариу өгч ажилласан.



Хуулийн этгээдийн улсын бүртгэгчид 1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчид 1, иргэний улсын бүртгэгчид 2 гомдол ирснийг тухай бүрт нь шийдвэрлэн зохих хариуг өгч ажилласан.

НАЙМ. БУСАД

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/130 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх, “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөнд идэвхитэй оролцлоо.



Жендерийн үндэсний хорооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Харилцан хүндэтгэе” сарын аяны хүрээнд “Хайраа хайрлая, хандлагаа өөрчлөө хамтдаа үлгэрлэе” уриан дор Албан хаагчид эерэг зан үйлдэл, хандлагыг байгууллагын www.dornod.burtgel.gov.mn сайт, Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн пэйж, фэйспүүк хуудсаар ишлэл үгээр, зурган хэлбэрээр олон нийтэд уриалж нэгдэн ажиллаласан.



Эх үрсийн баярыг тохиолдуулан албан хаагчдынхаа хүүхдүүдэд Оюунлаг бэлэг гардуулан өглөө.



Нийгмийн хариуцлагын хүрээнд АНУлсад бүжгийн тэмцээнд оролцсон “ӨСӨХ ИРЭЭДҮЙ” хамтлагийн хүүхдүүдэд болон улсын бүртгэлийн байгууллагын системд ажиллаж буй 2 албан хаагч, 1 цэцэрлэгийн багшийн ар гэрт хамт олны мөнгөн тусламж хандивыг тус тус цуглуулан хүргүүлсэн.



Дорнод аймгийн 2022 оныг “ЁС ЗҮЙГ ДЭЭДЛЭХ” зорилтот жилийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг дээдлэх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус хэлтэс нь “ХАНДЛАГАА ӨӨРЧИЛЬЕ-ХАРИЛЦААГАА ЭРХЭМЛЭЕ” сарын аянг 2022 оны 03 дугаар сард зохион байгуулсан.



“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ ЭРТЭЧ МОНГОЛ” аянд 2022 оны 03 дугаар сарын 02, 2022 оны 03 дугаар сарын 18, 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрүүдэд тус хэлтсийн албан хаагчид нэгдсэн.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Шинэ үеийн Гаалийн байгууллага үүсч хөгжсөний 110 жилийн ойг угтан зохион байгуулсан 3 талт тэмцээнд байгууллагаараа амжилттай оролцож, 4 дүгээр байр эзлэв.



ЕБС-ийн 10 дугаар ангийн сурагчид “Мэргэжил сонгох өдөрлөг”-ийн хүрээнд улсын бүртгэлийн хэлтсийн бүтэц, зохион байгуулалт болон иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаатай танилцлаа.



Бүсийн оношилгоо, эмчилгээний төв эмнэлэгт хэлтсийн нийт албан хаагчид эрт илрүүлгийн багц үзлэгт бүрэн хамрагдсан.



ТАЙЛАН БИЧСЭН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ОЮУНБАЯР